



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/528

Мөрөн сум

Төсөвт хөрөнгө задлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 682 дугаар захирамжаар батлагдсан Эрх зүй нийтийн хэв журам хөтөлбөрийн тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжид хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд батлагдсан 40,000,000 (дөчин сая) төгрөгийг Тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжид хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 10,000,000 (хорин сая) төгрөг, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Кабелийн худаг, сувагчлал, агаарын багана түрээслэх гэрээний дагуу Цагдаагийн хяналтын камерын худаг, сувагчлал, агаарын баганын түрээсийн төлбөр 5,550,180 (таван сая таван зуун тавин мянга нэг зуун наян) төгрөг, Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн Мөрөн сумын камерын цахилгаан эрчим хүчний хэрэглээний төлбөрт 5,167,505.38 (таван сая нэг зуун жаран долоон мянга таван зуун таван төгрөг гучин найман мөнгө) төгрөг, 19,282,314.62 (арван есөн сая хоёр зуун наян хоёр мянга гурван зуун арван дөрвөн төгрөг жаран хоёр мөнгө) төгрөг болгож өөрчлөн баталсугай.

2. Дээрх 40,000,000 (дөчин сая) төгрөгийн Тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжид хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 10,000,000 (арван сая) төгрөг, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Кабелийн худаг, сувагчлал, агаарын багана түрээслэх гэрээний дагуу Цагдаагийн хяналтын камерын худаг, сувагчлал, агаарын баганын түрээсийн төлбөрт 5,550,180 (таван сая таван зуун тавин мянга нэг зуун наян) төгрөг, Хөвсгөл-Эрчим Хүч ХХК-ийн Мөрөн сумын камерын цахилгаан эрчим хүчний хэрэглээний төлбөрт 5,167,505.38 (таван сая нэг зуун жаран долоон мянга таван зуун таван төгрөг гучин найман мөнгө) төгрөг, Эрх зүйн сургалт сурталчилгааны зардалд 19,282,314.62 (арван есөн сая хоёр зуун наян хоёр мянга гурван зуун арван дөрвөн төгрөг жаран хоёр мөнгө) төгрөг болгож задалж төсөвлөхийг аймгийн Засаг даргын Тамгын газар даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ